



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035

Утас/Факс: (976-11) 32-71-99

Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2022. 06. 07 № 0462988

танай _____ -ны № _____ -т

Г НИЙСЛЭЛИЙН НҮТГИЙН Т ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 192, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 194 дүгээр тогтоолыг тус тус хургуулж байна.

Хавсралт  хуудастай.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА 
У.ГАНБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 194

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Төрийн албаны тухай хуулийн 10.4, 18.8, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 20.4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 275 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ын "Нутгийн захиргааны байгууллагын албан тушаал"-ын "Удирдах" албан тушаалын ТЗ-12 зэрэглэлд "1. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга, 2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны хэлтсийн дарга, 3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хэлтсийн дарга, 4. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дарга" гэж, ТЗ-10 зэрэглэлд "1. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын тасгийн дарга, 2. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын нэгжийн дарга, 3. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, 4. Дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга, 5. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны тасгийн дарга", "9. Аймаг, нийслэл дэх төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга" гэж, ТЗ-8 зэрэглэлд "1. Дүүргийн Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга, 2. Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн дарга, 3. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны нэгжийн дарга" гэж, ТЗ-7 зэрэглэлд "1. Дүүргийн Засаг даргын тамгын газрын тасгийн дарга" гэж, "Гүйцэтгэх" албан тушаалын ТЗ-8 зэрэглэлд "1. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын ахлах мэргэжилтэн, 2. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ахлах мэргэжилтэн, 3. Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхий нягтлан бодогч, 4. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн" гэж, ТЗ-7 зэрэглэлд "1. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн, 2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ажилтан, 3. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн, 4. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын ахлах мэргэжилтэн", "6. Сум, дүүргийн төсвийн ерөнхий нягтлан бодогч, 7. Төрийн сангийн ахлах мэргэжилтэн (дотоод хяналт, нягтлан бodoх бүртгэл, төсөв хариуцсан)" гэж, ТЗ-6 зэрэглэлд "1. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын мэргэжилтэн, 2. Дүүргийн Засаг даргын тамгын газрын ахлах мэргэжилтэн, 3. Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн ахлах мэргэжилтэн, 4. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн", "10. Төрийн сангийн мэргэжилтэн (төлбөр тооцоо хариуцсан)" гэж, ТЗ-5 зэрэглэлд "1. Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ажилтан, 2. Дүүргийн Засаг даргын тамгын газрын мэргэжилтэн, 3. Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн мэргэжилтэн" гэж, ТЗ-4 зэрэглэлд "2. Сумын Засаг даргын тамгын газрын


мэргэжилтэн" гэж, "Туслах" албан тушаалын Т3-4 зэрэглэлд "1.Хорооны нийгмийн ажилтан, 2.Хорооны бүртгэл мэдээлэл, зохион байгуулалтын асуудал хариуцсан ажилтан, 3.Сумын нийгмийн ажилтан" гэж тус тус нэмсүгэй.

2. Мөн жагсаалтын "Нутгийн захиргааны байгууллагын албан тушаал"-ын "Удирдах" албан тушаалын Т3-11 зэрэглэлийн "5" гэснийг "1" гэж, Т3-10 зэрэглэлийн "2" гэснийг "6", "3" гэснийг "7", "4" гэснийг "8" гэж, Т3-9 зэрэглэлийн "5" гэснийг "1", "6" гэснийг "2" гэж, Т3-7 зэрэглэлийн "1" гэснийг "2", "2" гэснийг "3", "5" гэснийг "4" гэж, "Гүйцэтгэх" албан тушаалын Т3-6 зэрэглэлийн "10" гэснийг "9" гэж, Т3-5 зэрэглэлийн "2" гэснийг "4", "3" гэснийг "5", "4" гэснийг "6", "5" гэснийг "7", "6" гэснийг "8", "10" гэснийг "9" гэж, Т3-3 зэрэглэлийн "2" гэснийг "1" гэж тус тус өөрчилсүгэй.

3. Мөн жагсаалтын "Нутгийн захиргааны байгууллагын албан тушаал"-ын "Удирдах" албан тушаалын Т3-11 зэрэглэлийн "1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, 2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны хэлтсийн дарга, 3.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны хэлтсийн дарга, 4.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дарга" гэснийг, Т3-10 зэрэглэлийн "1.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын дэд дарга" гэснийг, Т3-9 зэрэглэлийн "1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын тасгийн дарга, 2.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын нэгжийн дарга, 3.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, 4.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга", "7.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны тасгийн дарга" гэснийг, Т3-7 зэрэглэлийн "3.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга, 4.Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн дарга", "6.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны нэгжийн дарга" гэснийг, "Гүйцэтгэх" албан тушаалын Т3-7 зэрэглэлийн "1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын ахлах мэргэжилтэн, 2.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ахлах ахлах мэргэжилтэн, 3.Нийслэлийн төсвийн ерөнхий нягтлан бодогч, 4.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн" гэснийг, Т3-6 зэрэглэлийн "1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн, 2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ажилтан, 3.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн, 4.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын ахлах мэргэжилтэн", "9.Аймаг, дүүргийн төсвийн ерөнхий нягтлан бодогч" гэснийг, Т3-5 зэрэглэлийн "1.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нутгийн захиргааны байгууллагын мэргэжилтэн", "7.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын ахлах мэргэжилтэн, 8.Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн ахлах мэргэжилтэн, 9.Сумын төсвийн ерөнхий нягтлан бодогч", "11.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн" гэснийг, Т3-4 зэрэглэлийн "2.Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ажилтан, 3.Дүүргийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн, 4.Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн мэргэжилтэн" гэснийг, Т3-3 зэрэглэлийн "1.Сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн" гэснийг, "Туслах" албан тушаалын Т3-3 зэрэглэлийн "1.Хорооны нийгмийн ажилтан, 2. Хорооны бүртгэл мэдээлэл, зохион байгуулалтын асуудал хариуцсан ажилтан, 3.Сумын нийгмийн ажилтан" гэснийг тус тус хассугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдон гарах нэмэлт зардлыг 2022 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлж, цаашид жил бүр холбогдох төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгасугай.

5. Энэ тогтоолыг 2022 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

А.АРИУНЗАЯА



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 192

Улаанбаатар
хот

Тогтоол, тогтоолын хавсралтад
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 57,14-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар баталсан "Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ"-г дор дурдсанаар өөрчилж, 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй:

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРААС БУСАД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГА БОЛОН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭВИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАХАД ТУСЛАХ АЛБАН
ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ХЭМЖЭЭ**

(сард, төгрөгөөр)

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн доод хэмжээ
TY-1	523405
TY-2	549250
TY-3	569585
TY-4	590937
TY-5	635776
TY-6	709759
TY-7	766481
TY-8	797676
TY-9	895945
TY-10	924695
TY-11	932617
TY-12	995822

2. Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчилсөнтэй холбоотойгоор шаардагдах хөрөнгийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.


3. "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 9-ний

өдрийн 107 дугаар тогтоолын 2 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2. Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлсийг салбарын онцлог болон албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харгалzan нэмэгдүүлж олгох асуудлыг зохицуулахад чиглэсэн арга хэмжээг батлагдсан төсвийн багцынхаа хүрээнд хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг төсвийн холбогдох ерөнхийлөн захирагч нарт зөвшөөрсүгэй."



Монгол Улсын Ерөнхий сайд



Хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

А.АРИУНЗАЯА